

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **“Ширээгийн голын 90.9 у/м төмөр бетон гүүр /Завхан, Цагаанхайрхан сум/”** -ийн төслийн барилга усралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

Тендер шалгаруулалтын дугаар: **ЗТХЯ/201801009**

Зам, тээврийн хөгжлийн яам нь Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт дахь “XIV.1.1.39 Ширээгийн голын төмөр бетон гүүр, 90.9 у/м /Завхан, Цагаанхайрхан сум/ төслийн барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэх цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулагдана.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50 000 /тавин мянга/** төгрөгөөр цахимаар худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч хуулийн этгээд нь ТБОНӨХБАҮХАТ Хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох ба дараах туршлагын болон санхүүгийн ерөнхий шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

- Төмөрбетон гүүрийн барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх,
- Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь 1 500 000 000 /нэг тэр бум таван зуун сая/ төгрөгөөс багагүй байх,
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: 300 сая төгрөгнөөс багагүй байх,
- Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 онуудын аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж гүйцэтгэсэн байх. /Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана./
- Тендерийн хамт 23 000 000 /хорин гурван сая/ төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн 11.00 цагаас** өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 11.30 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.  
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендертэй холбоотой тодруулга, мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Зам, тээврийн хөгжлийн яам,  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,  
Засгийн газрын 13-р байр, 409 тоот өрөө.  
АЗБХЗГ-ын мэргэжилтэн Б.Ууганбаяр. Утас: 62263187**